



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/25

Бэрх хот

**Дэмжлэг үзүүлж, хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх" тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дах заалт, Хэнтий аймгийн Цагдаагийн газрын Батноров сумын сум дундын цагдаагийн тасгийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 51г/04 тоот албан бичиг, Захирагчийн зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн №03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотоор олон улсын чанартай төв магистрал засмал зам дамжин өнгөрч байгаатай холбогдуулан иргэд, жолооч, зорчигчдын хөдөлгөөн ихсэж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, зам тээврийн ослын гаралт нэмэгдэх хандлагатай байгаа тул хяналт шалгалтыг эрчимжүүлэхэд зориулж согтуурал шалгах багаж авах зардалд 4.740.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах 4.740.000 (Дөрвөн сая долоон зуун дөчин мянган) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хууль, дүрэм журмын дагуу зарцуулахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

23250:005